



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ДҮНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2017.02.22 № 0137 ДУА -2017/10% СТА -ТЦУЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайландауд аудит хийх явцад төрийн үйлчилгээний албан хаагч нарт 820,000.00 /найман зуун хорин мянга/ төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулалт олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн албаны тухай хууль 9 дугаар зүйлийн 9.1-д /Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараахъ албан тушаал хамаарна/, 9.1.1-д /төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал/, 31.3-т /Төрийн албан хаагчийг энэ зүйлийн 31.1.1, 31.1.2-т заасан шагналаар шагнах болон мөн зүйлийн 31.2-т заасан мөнгөн урамшил олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар, энэ зүйлийн 31.1.3-т зааснаар шагнаалд тодорхойлох журмыг хуулиар тус тус тогтооно/, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.1-д /Төсвийн ерөнхийлөн захирагч төрийн жинхэнэ албан хаагч-төсвийн шууд захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэхэд энэ журмыг баримтална/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гээж узсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

ХУЛД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.СҮХДОРЖ ТАНАА

199900712

- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх
- Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Хулд сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Сүхдорж, нягтлан бодогч Ч.Хүүхэнбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ

Ж.УГТАХБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА

С.СҮХДОРЖ

Ч.ХҮҮХЭНБААТАР

37000001

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/